



PREMIUM
BUILDING MATERIALS



PREMIUM
BUILDING MATERIALS

ЭРХЭМ ЗОРИЛГО

Хөгжлийн илэрхийлэл болох барилга дэд бүтцийн материалын нийлүүлэлтийг мэргэшсэн багийн хүчээр инновацид тулгуурласан технологийн дэмжлэгтэйгээр, аюулгүй эрүүл орчинд үнэ цэнийн хамт хүргэгч, оролцогч талуудын хүлээлтийг байнга давуулсан сэтгэл ханамжаар үр дүнгээ тодорхойлогч байна.

ҮНЭТ ЗҮЙЛС

Шударга зарчим , Аюулгүй ажиллагаа,
Чанар, Сайжруулалт

АЛСЫН ХАРАА

Хөгжлийг дэмжигч, хүнийг эрхэмлэгч, төгс бүтээгдэхүүн үйлчилгээнд тэмүүлэгч, барилга, дэд бүтцийн салбарын хамт олон байна.

“Премиум Бьулдинг Материалс” ХХК нь 2011 онд “Премиум Конкрит” нэртэйгээр 100% дотоодын хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан бөгөөд олон улсын стандартад нийцсэн өндөр чанарын бетон зуурмаг болон барилгын материалыг нийлүүлэхэд шаардлагатай шийдлүүд бүхий цогц үйл ажиллагааг явуулж байна.



БЭЛЭН БАЙДАЛ

Ажлын капиталыг оновчтой хуваарилан хэрэглэгчдэд хэдийд ч, хаана ч шаардлагатай хэмжээгээр бүтээгдэхүүн үйлчилгээг нийлүүлэхэд бэлэн байна.



МЭРГЭШСЭН БАЙДАЛ

Бид орчин үеийн технологийн шийдлийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэглэгчдэд шаардлагатай бүтээгдэхүүн үйлчилгээг тасралтгүй, тогтмол чанартай, аюулгүй байдлыг бүрэн хангасан нөхцөлд нийлүүлнэ.



ХАРИУЦЛАГАТАЙ БАЙДАЛ

Үйлдвэрлэл, үйл ажиллагаандаа ашиглаж буй шийдэл нь байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл хамгийн бага байлгахад чиглэдэг.

ОН ЦАГИЙН ХЭЛХЭЭС

PREMIUM
concrete



American Concrete Institute

2011
Премиум Конкрит
компани байгуулагдав.

2012
Монголын
Барилгын Материал
Үйлдвэрлэгчдийн
Холбооны гишүүн,

2012
Монголын Бетоны
Холбооны гишүүн
байгууллага болов.

2012
Америкийн Бетоны
Институтын гишүүн
байгууллага болов.

2012
АНУ-ын Үндэсний Бетон
Зуурмагийн
Ассоциацийн NRMCA
итгэмжлэл авав.

2012
ASTM C94 стандарт
ангиллаар “Хүнд
нөхцөл”-д C35/45 маркийн
бетон үйлдвэрлэгч
болов.



PREMIUM
BUILDING MATERIALS

2013

Pavement буюу зурвасын даацын бетон үйлдвэрлэгч,

2013

Cement Stabilized Base буюу цемент агуулсан суурийн хольц үйлдвэрлэгч,

2013

W6-W12 төрлийн ус тусгаарлагч бетон үйлдвэрлэгч болов.

2014

C40 маркийн бетоныг анх удаа өвлийн улиралд нийлүүлэв.

2012-2017

Бетоны олон улсын хурал семинарын ивээн тэтгэгч, оролцогч, зохион байгуулагчаар ажиллав.

2017

Монгол улсын цор ганц шүршдэг бетон үйлдвэрлэгч болов.


2018

Премиум Конкрет компани Премиум Бюлдинг Материалс компани болж өргөжив.

2018

Монголын барилга, дэд бүтцийн салбарт 1000000м³ бетон зуурмагийг үйлдвэрлэн нийлүүлсэн анхдагч байгууллага болов.

Хөгжлийг дэмжигч,
хүнийг эрхэмлэгч,
төгс бүтээгдэхүүн
үйлчилгээнд
тэмүүлэгч, барилга,
дэд бүтцийн
салбарын хамт
олон





PREMIUM
BUILDING MATERIALS

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨРӨЛ



БЕТОН ЗУУРМАГИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ

NRMCA-ийн сертификат бүхий Улаанбаатарт 4 үйлдвэр, Өмнөговь аймгийн Цогтцэций суманд, Дорноговь аймгийн Сайншанд хотод тус тус 1 үйлдвэр ажиллаж байна. Дээрх үйлдвэрүүд нь жилдээ 300,000 м3 бетон зуурмагийн зах зээлд нийлүүлэх хүчин чадалтай.



ХҮРГЭЛТ, ҮЙЛЧИЛГЭЭ

Хэрэглэгчийн хэрэгцээт талбайд замын хөдөлгөөн, хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангасан GPS, RFID, холбооны хэрэгслээр тоноглогдсон технологийн тээврийн хэрэгслээр (миксер) товлосон цагт хүргэн өгч, 60 хүртэл метрийн урттай бетон зуурмаг шахуургат төхөөрөмжөөр үйлчилж байна.



ТЕХНИКИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Бетон зуурмагийн ашиглалт, цутгалтын болон арчилгаан дээр дотоодын ба олон улсын мэргэжилтнүүд зөвлөх үйлчилгээ үзүүлдэг.



ЛАБОРАТОРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Манай лаборатори нь АНУ-ын дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн HUMBOLDT брэндийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон бөгөөд ISO:17025 стандартын шаардлагад нийцсэн, итгэмжлэгдсэн лаборатори юм. Тус лаборатори нь бетон зуурмагийн болоод ашиглагдаж байгаа түүхий материалын сорьцын шинжилгээг хийхээс гадна хэрэглэгчдэд бетон хүлээн авах арга аргачлал, арчилгааны талаар зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлж байна



БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН НИЙЛҮҮЛЭЛТ

Барилга угсралтад ашиглагддаг бетон эдлэл, цемент, дүүргэвч болон бусад материалуудыг түргэн шуурхай, найдвартай, тасралтгүйгээр нийлүүлдэг.



ТЕХНИКИЙН ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

Дотоодын болон олон улсын мэргэжилтнүүд бетон ашиглалт цутгалтын үйл ажиллагааны заавар зөвлөмж.

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОНЦЛОГ, БАРИМТЛАХ ЗАРЧИМ



Аливаа төсөл цаг хугацаандаа хэрэгжиж, үр ашиг, үнэ цэнээ бүрэн өгөх эсэх нь бүтээгдэхүүний чанар, аюулгүй ажиллагаа, тасралтгүй ханган нийлүүлэлтээс шууд хамаардаг.

Бараа материал нийлүүлэгч компанийн хувьд бид дээрх бүх нөхцлийг биелүүлэхийг зорилго болгон алба хоорондын дотоод зохион байгуулалт, уялдаа холбоог сайжруулж, учирч болох эрсдэлийг урьдаас үнэлэн, үйлдвэрлэл, үйл ажиллагааны бэлэн байдлыг дээд зэргээр хангасан төлөвлөлтийг хийхэд өндөр ач холбогдол өгч ажилладаг билээ.

Харилцагч нэг бүрийн хүсэл шаардлагад нийцсэн бетон зуурмаг, барилгын материалыг хэзээ ч, хаана ч, хэрэгцээт хэмжээгээр, эрсдэлгүйгээр нийлүүлэх нь “Премиум Бьюлдинг Материалс” компанийн гол зарчим юм.


Бид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, байгаль орчны чиглэлийн үйл ажиллагаагаа тасралтгүй сайжруулах замаар олон улсын жишигт хүрсэн, салбарын шилдэг шийдэл бүхий тогтолцоотой компани болж, ослоос хамаарсан сул зогсолт, ажлын бүтээмжийн бууралтыг боломжит доод түвшинд хүргэх зорилгыг өмнөө тавин ажиллаж байна.

ХҮНИЙ НӨӨЦ



НИЙТ АЖИЛЧДЫН ТОО:


161



АЖИЛЛАХ ХҮЧНИЙ УР ЧАДВАР



САЛБАРТ АЖИЛЛАСАН ТУРШЛАГА



АСИ сертификаттай инженер нь: (American Concrete Institute) Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эрх бүхий инженер стандартын дагуу туршилт шинжилгээ хийж баталгаажуулдаг.

МЭРГЭЖЛИЙН УР ЧАДВАРЫН СУРГАЛТ 2012-2017

ХИЛИЙН ЧАНАДАД

5



Сургалтын тоо

30



Сургалтанд хамрагдсан ажиллагсдын тоо

КОМПАНИ ДОТРОО

30



Сургалтын тоо

170



Сургалтанд хамрагдсан ажиллагсдын тоо

ДОТООДЫН

34



Сургалтын тоо

75



Сургалтанд хамрагдсан ажиллагсдын тоо

БЕТОН ЗУУРМАГИЙН НИЙЛҮҮЛЭЛТ



ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БЭЛЭН БАЙДАЛ

- Түүхий эд материалын бэлэн байдал
- Сэлбэг хэрэгслийн бэлэн байдал
- Тоног төхөөрөмж, техник хэрэгслийн бэлэн байдал

ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ


- Мэргэшсэн боловсон хүчин, чадварлаг инженер техникийн ажилчид
- Сургалт, хөгжлийн бодлого
- Ажиллах таатай орчин, байгууллагын соёл

ЭРСДЛИЙН УДИРДЛАГА

- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа
- Түүхий эд материалын аюулгүйн нөөц
- Даатгагдсан бүтээгдэхүүн үйлчилгээ


2012-2017 ОНД НИЙЛҮҮЛСЭН БЕТОН ЗУУРМАГ

1,000,000 м³



Burj Khalifa x 3

=



New Ulaanbaatar
International Airport x 4

=



Shangri-La hotel
Ulaanbaatar x 4

СУДАЛГАА ХӨГЖЛИЙН АЛБА



Бид Монгол улсынхаа бетон үйлдвэрлэл ба бетоны эрдэм шинжилгээ, судалгааны хөгжлийг холбох гүүр болох том зорилтыг өмнөө тавин ажиллаж байна. Манай компани нь “Америкийн Бетоны Институт”-ын (ACI) гишүүн учраас дэлхий даяар хэрэгжиж буй томоохон төслүүд болон салбарын тэргүүн туршлага, шинжилгээ судалгааны мэдээлэл, төрөлжсөн сургалт, хамтын ажиллагааны өргөн боломж бидэнд нээлттэй байдаг. Мөн хөгжингүй орнуудын бетоны мэргэжилтнүүдтэй холбогдон туршлага судлах, хамтран ажиллах бололцоотой юм.



СУДАЛГАА ХӨГЖЛИЙН АЛБА ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ТӨСЛҮҮД

Шинэ бүтээгдэхүүн, хөгжүүлэлт

- Механик элс
- Өөрөө нягтардаг бетон зуурмаг
- Нано бетон зуурмаг
- Өндөр бат бөхтэй бетон зуурмаг

Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл


- Механик элс үйлдвэрлэх
- Саарал усыг бетон зуурмагийн үйлдвэрлэлд ашиглах
- Хаягдал бетон зуурмагийг дахин ашиглах
- Агаарын бохирдол бууруулах шинж чанар бүхий бетон зуурмаг үйлдвэрлэх

Эх дэлхий, эх орон, хүрээлэн
буй орчноо хайрлан хамгаалж
үр хүүхэд хойч ирээдүйдээ
өвлүүлэн үлдээе.




БАЙГАЛЬ ОРЧИН

Нийгмийн хариуцлагынхаа хүрээнд байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай бизнесийн үйл ажиллагаа явуулахыг зорьж, судалгаа шинжилгээг тасралтгүй хийн, бодит үр дүнд хүрч байна



СУРГАЛТ ХӨГЖИЛ

Аливаа бүтээн байгуулалт, үйл ажиллагааг техник дангаар хийдэггүй, хүн гол цөм нь байдаг гэдэгтэй та санал нийлэх биз ээ. Тийм ч учраас манай компани хүний нөөцөө сургах тал дээр цаг ямагт анхаарч, гадаад дотоодын сургалтуудад мэргэжилтнүүдээ тогтмол хамруулдаг юм.




Герман улсын Trarobet, BASF, бетон зуурмагийн үйлдвэрүүдийн үйл ажиллагаатай танилцан, хамтарсан судалгаа шинжилгээ туршилтыг хийсэн.



АНУ-ын Бетоны холбооны олон улс хариуцсан гишүүн, Швейцари улсын мэргэжилтэн Кристоф Харинг манай компанийн урилгаар ирж сургалт өгч байв.




АНУ-ын Бетоны институтын эрдэмтэн, зөвлөх Лүк М.Снеллтэй хамтран ажиллаж, АНУ-д төвтэй Үндэсний Бетон Зуурмагийн Ассоциацаас олгодог “Олон улсад бетон зуурмагийн үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах” эрхийн гэрчилгээг \NRMCA\ авсан.



БНХАУ -ын өвлийн улиралд ажилладаг бетон зуурмагийн үйлдвэрүүдэд инженер, техникийн ажилтнуудаа явуулж туршлага солилцож, танилцуулах сургалт зохион байгуулсан.



Японы Тохоку Их Сургуулийн профессор багш Динил Пушпалалтай хамтран ажиллаж сургалт, зөвлөгөө, судалгаа шинжилгээг тогтмол явуулсаар байна.



АНУ-ын Лас Вегас хотод зохион байгуулагддаг “World of Concrete” барилгын салбарын үзэсгэлэн худалдаанд манай инженерүүд тогтмол оролцож, туршлага судлан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдээ худалдан авч үйлдвэрлэл, судалгаа шинжилгээндээ ашиглаж байна.


ЧАНАРЫН УДИРДЛАГА

Манай компани хэрэглэгчиддээ ямагт дээд зэргийн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлэх зорилгоор өөрийн үйлдвэрлэл, үйл ажиллагааны тогтолцоог цаг ямагт сайжруулан хөгжүүлдэг. Үйлдвэрлэлийн процессыг бүхэлд нь буюу шат дамжлага бүрийг нь хамарсан чанарын хяналт, чанарын баталгааны нарийн систем нэвтрүүлэн хэрэгжүүлж байна.



ОНЦЛОХ ТӨСЛҮҮД

Орон сууц





Buddha Vista

БНСУ-ын дэвшилтэт шинэ технологийн дагуу барьсан 109 айлын дээд зэрэглэлийн орон сууцны барилга.



Asem Village

Асем виллаж төсөл нь дээд зэрэглэлийн зохион байгуулалттай, нийт 360м², 500м² гэсэн 2 сонголттой 53 ширхэг Вилла болон Club House үйлчилгээний цогцолбороос бүрдэнэ.



River Garden

7.5 га газрыг хамран байрлах ба 360 айлын таун хаус, пент хаус, 6-15 давхар орон сууцны барилга, оршин суугчдад хэрэгцээт худалдаа үйлчилгээг цогцоор нь шийдсэн ногоон хотхон юм.



Time Square

Time Square хотхон нь нийт 4,8 га газрыг хамран байрлах ба 350 айлын 16 давхар орон сууц болон худалдаа үйлчилгээний төвөөс бүрдэх цогцолбор хотхон юм.



Белла Виста

Белла Виста төсөл нь нийт 222 таунхаус, дуплекс орон сууц, пентхаусыг багтаасан өндөр зэрэглэлийн орон сууцны хотхон юм.



King Tower

Франц архитекторын зургаар, 5 одтой зочид буудлын стандартаар цогцлоож буй өндөр зэрэглэлийн 5000 айлын орон сууцны барилга



VIP Residence

VIP residence нь бүрэн цутгамал үндсэн хийцтэй, олон улсын стандартыг хангасан барилгын материалуудаас бүрдсэн. Английн Викториа хэв маягийн архитектурын төлөвлөлттэй, оршин суугчдын тав тух, амар амгалан байдлыг хангасан, худалдаа үйлчилгээний нэгдсэн төвтэй.



Mandala

Мандала нь 2,3 га газарт хүүхдийн тоглоомын талбай, усан оргилуур, автомашины нэгдсэн дулаан зогсоол, үйлчилгээний төвүүд болон дэд бүтцийн цогц шийдэл бүхий 15 давхар, бүрэн цутгамал, 12 блок 626 айлын орон сууцны хотхон юм.

ОНЦЛОХ ТӨСЛҮҮД

Үйлчилгээ, оффис

- Шангри-Ла худалдаа
үйлчилгээний төв
- Хаан Тауэр оффис болон
орон сууц




Shangri-La Centre
ULAANBAATAR





Хотын захиргааны шинэ байр

Шинэ хотын захиргаа нь 5 га газар баригдаж буй Нийслэлийн ИТХ, Тамгын газар, Нийслэлийн харьяа 33 газар, агентлаг болон урлаг, хурлын үйл ажиллагаа явуулах конвейшн төв байрлах барилга юм.



River Plaza

River Plaza нь 6 өнцөгт экстерьерийн онцгой шийдэл бүхий бүх төрлийн үйлчилгээний төвтэй, бизнес ангилалын 23 давхар 168 айлын орон сууц.

The background is a solid red color. Overlaid on this are several thin, white, geometric lines that intersect to form various polygons, primarily triangles and quadrilaterals. The lines are scattered across the right and bottom portions of the image, creating a complex, abstract pattern.

ОНЦЛОХ ТӨСЛҮҮД

Дэд бүтэц, уул
уурхай



Салхит, Цогт цэций, Сайншандын салхин сэнсний төсөл


Сэргээгдэх эрчим хүчний нэгэн эх үүсвэр болох салхин сэнсний төслүүдэд C40 маркийн бетон зуурмаг нийлүүлэлтийг дарааллан хийж байна. ASTM C94 стандартын дагуу эрс тэс уур амьсгалд зохицохуйц, агаарын агууламж өндөртэй бетон нийлүүлсэн.

Дэлхийн алдарт BASF компанитай хамтран химийн нэмэлт болох Glenium 102; Micro air 202 бодисуудыг үйлдвэрлэлд нэвтрүүлэв. Энэхүү төсөлд оролцсоноор хөрсний хөлдөлт, гэсэлтэд тэсвэртэй бетон зуурмагийг бүхий л төрлийн барилга угсралтын төслүүдэд нийлүүлэх боломжтойг харуулж, туршлага хуримтлуулсан.



Олон улсын нисэх онгоцны буудал

Хөшигийн хөндийд байрлах Чингис хаан олон улсын шинэ нисэх онгоцны буудлын төсөлд 240.000 орчим м³ бетоныг 2.5 жилд үйлдвэрлэж нийлүүлэх олон улсын тендерт шалгарснаар төслийн талбайд 4 үйлдвэр байгуулж, тусгай зориулалтын бетон зуурмагийг 24/7 нөхцлөөр тасралтгүй нийлүүлсэн. Энэхүү төсөлд оролцсоноор цаашид олон улсын стандартад (IATA) нийцсэн өндөр хурдны замын төсөлд бетон зуурмаг нийлүүлэх боломжтойг харууллаа.



“Оюутолгой” далд уурхайн төсөл

Дэлхийн хэмжээний том төсөл болох “Оюутолгой” төслийн далд уурхайд шүршдэг бетон нийлүүлсэн анхны монгол компани болов. Төслийн талбайд бетон зуурмагийн үйлдвэр дөрвийг угсарч, аюулгүй ажиллагааг өндөр түвшинд хангаж, бүтээгдэхүүнийг тасралтгүй нийлүүлж байна.

Монгол улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнескогийн
гудамж, “МПМ” цогцолбор, 12 давхарт
“Премиум Бьюдинг Материалс” ХХК

Утас: 7777-3311
www.premiumbm.mn